



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

Захиргааны хэлтэст  
2020 оны 02 сарын 06-ны  
өдрийн 4696 дугаарт бүртгээ.

2019 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

“Шуудангийн харилцан холболтын журам”-ыг шинэчлэн  
батлах тухай

Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дах заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шуудангийн харилцан холболтын журам”-ыг энэхүү тогтоолын хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хорооны 2017 оны 16 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/- д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ



Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн  
54 тоот тогтоолын  
хавсралт

## ШУУДАНГИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.4, Шуудангийн тухай хуулийн 9.1.5 дах заалтуудыг тус тус үндэслэн улс хоорондын болон дотоодын шуудангийн үйлчилгээг үзүүлэхэд гардаг алдагдлыг бууруулах, үйлчилгээ эрхлэгчдийн хамтын ажиллагаа, салбарын эдийн засгийн өсөлтийг дэмжихэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Шуудангийн сүлжээ байгуулах, түүний ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид /цаашид Талууд гэх/ өөр хоорондоо харилцан холболт хийхдээ Иргэний хууль, энэхүү журмыг үндэслэн харилцан холболтын гэрээ байгуулна.

1.3. Нийтийн шуудангийн үйлчилгээг үзүүлэх харилцан холболт нь дараах төрөлтэй байна:

1.3.1. Сүлжээ байгуулах, түүнийг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд;

1.3.2. Сүлжээ байгуулах, түүнийг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч болон шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд;

1.3.3. Шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд.

1.4. Харилцан холболтын технологийн нөхцөл нь шуудангийн үйлчилгээний стандартын шаардлага хангасан технологийн горим, шуудангийн илгээмжийг хүргэх хугацааны үзүүлэлтүүд байна.

### ХОЁР. ШУУДАНГИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТ ХИЙХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1. Талууд нь харилцан холболт хийхдээ ижил нөхцлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх зарчмыг баримтална.


2.2. Харилцан холболт хийх үйлчилгээний тариф нь бизнесийн аливаа алдагдлыг нөхөхгүй, өртөгт үндэслэсэн, талуудын эрх ашигт нийцсэн байна.

2.3. Талууд харилцан холболт хийх нөхцөл, шаардлага, төлбөр, гэрээний загварыг нээлттэй байлгана.

2.4. Харилцан холболтын явцад шинэ техник, технологи, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхтэй холбоотой нэмэлт хөрөнгө оруулалт, зардлыг талууд харилцан тохиролцоно.

### ГУРАВ. ШУУДАНГИЙН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

3.1. Талууд харилцан холболтын гэрээг байгуулахдаа дараах нөхцлүүдийг тусгана:



3.1.1. Шуудангийн илгээмжийг хүлээх авах, ялган боловсруулах, дамжуулах, хүргэлтэнд мөрдөгдөх, стандарт технологийн горим, хүргэлтийн графикт маршрутаар тооцон гаргасан илгээмжийг хүргэх хугацаа, мэдээлэл солилцох;

3.1.2. Шуудан солилцох зааглах цэг, илгээмж солилцох байр талбай, үйлчилгээний нөхцөл нь талуудын шуудан солилцох үйлчилгээний салбар цэг байх ба үйлчилгээний хамрах хүрээний хувьд давхцсан байна.

3.1.3. Харилцан холболтын үйлчилгээ үзүүлэхдээ өөрийн үйлчилгээний чанарын үзүүлэлтээс бууруулахгүйгээр ажиллах;

3.1.4. Зааглах цэг хүртэлх илгээмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хариуцах;

3.1.5. Үйлчилгээнд нөлөөлөх, эсвэл үйлчилгээг тасалдуулж болзошгүй саатал болон амралтын үеийн хуваарийг харилцан холбогдсон талуудад яаралтай мэдэгдэж шуурхай арга хэмжээ авах.

3.1.6. Талууд харилцан холболтын тарифыг Шуудангийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу үйлчлэгчийн эрх бүхий этгээдээр батлуулан мөрдөнө.

3.2. Талууд төлбөр тооцоход дараах нөхцлийг харгалзана:

3.2.1. Харилцан холболтын төлбөр тооцоог солилцсон шуудангийн гадуур болон дотуур дагаврын маягтад үндэслэх;

3.2.2. Харилцан холболтын төлбөр тооцоог нийлэх хугацааг тохирох.

## ДӨРӨВ. БУСАД

4.1. Энэхүү журам, гэрээг зөрчсөн болон харилцан холболттой холбоотой бусад маргаантай асуудлыг Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.12-т заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэнэ.

4.2. Талууд, харилцан холболтын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 10 хоногийн дотор гэрээний хуулбарыг ирүүлж, Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлнэ.

4.3. Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэхүү журмын дагуу байгуулагдаагүй гэрээг бүртгэхээс татгалзах эрхтэй.

4.4. Талууд нь өөрийн үйлчилгээг өргөтгөх, шинэчлэх, татан буулгах зэрэг өөрчлөлтөөс үүдэн харилцан холболтод нөлөөлөхүйц нөхцөл байдал үүсэхээр бол мэдээллийг 3 сарын өмнө холбогдох талуудад болон Харилцаа холбооны зохицуулах хороонд мэдэгдэнэ.

-о О о-

